

ДУУРИЙН УРЛАГИЙН ҮҮСЭЛ

Дэлхийн урлагийн түүхэнд XVII-XVIII зууны дунд үед Барокко хэв маяг ноёрхох болжээ. Энэ үед хийл, альт, виолончель зэрэг хөгжмийн зэмсгүүд шинээр бий болжээ. Үүний зэрэгцээ дуурь, концерт, сюит зэрэг дуулаач, дан хөгжмийн шинэ төрлүүд үүсэж хөгжсөн. Энэ үеийн урлагийн гол шинж болсон нийгмийн хямрал зөрчлийг хүчдэлийн эрс тэс өөрчлөлт, гоцлол ба хамсраа хөгжмүүдийн ялгарлаар илүү нарийн дүрслэх болжээ.

Хөгжим, яруу найраг, театр, бүжиг, дүрслэх урлаг гэх мэт урлагийн олон төрлүүд нийлж бүтсэн дуурь хэмээх том төрөл Италид үүсжээ. Дэлхийн хөгжмийн түүхэнд анхны дуурь хэмээн тооцогддог бүтээл бол Флоренц хотноо 1597 онд тоглогдсон хөгжмийн зохиолч Якопо Пери, цомнол зохиогч Оттавио Ринуччини нарын “Дафна” дуурь юм. Улмаар Италийн Ром, Венец, Неаполь хотуудаар тархан хөгжихдөө дуурь нь жинхэнэ сонгодог төрхөө олжээ.

400 гаруй жилийн түүхтэй дуурь нь янз бүрийн салбарын, хамгийн олон мэргэжлийн хүнийг хамарч бүтдэг, хамтын бүтээл юм. Өгүүлэх утга агуулгын цар хүрээ, үзүүлэх дүрслэлийн нөхцөл боломж, хамрах үзэгчдийн тоо болон тэдний сэтгэл санаанд нөлөөлөх увдисаараа урлагийн хамгийн том төрөлд тооцогддог. Дуурь бий болсон нь урлагийн түүхэн дэх агуу их нээлт байсан билээ.

Дэлхийн томоохон дуурийн театруудын барилга, улсын далбаагаар Ковент Гарден, Большой театр, Сиднейн дуурийн театр, Метрополитен-опера, Ла Скала, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн театрыг олоорой. Хэрхэн яаж олсноо тайлбарлаарай.



Дуурийн төрөл

Дуурь нь тус тусдаа орших урлагийн төрлүүдийг нэгтгэдгээрээ давуу талтай юм. Мөн цомнол зохиогч, хөгжмийн зохиолч, найруулагч, удирдаач, зураач, бүжиг дэглээч, найрал дууны удирдаач, дуучин, хөгжимчин, бүжигчин, тайзны гэрлийн техникч гээд олон мэргэжлийн хүмүүсийн хамтын хөдөлмөрийн үр дүнд бүтдэг. Дуурийн уран зохиолын эх материалыг дуурийн урлагийн онцлогт нийцүүлэн эмхэтгэснийг "Цомнол зохиол" гэж нэрлэдэг.

Италийн дуурийг агуулга, хөгжмийн илэрхийлэх онцлогоос хамааран дотор нь Сериа дуурь (төлөв), Буффа дуурь (хошин) гэж үндсэн 2 төрлөөр хөгжиж иржээ. Улмаар дэлхий даяар тархахдаа тухайн улс үндэстний онцлогоос хамааран өөр өөр нэрлэгдэж ирсэн байна. Тухайлбал, Францад "Уянгын эмгэнэлт драм", Германд "Зингшпиль", Англид "Ядуусын дуурь", Испанид "Сарсуэлла" гэх мэт. Үндэснийхээ ахуй соёл, ардын дуу хуурт түшиглэн хөгжсөн Итали, Герман, Франц, Орос, Монгол зэрэг дэлхийн улс орнуудын үндэсний дууриуд нь тухайн нийгэм, цаг үеийнхээ эрэлт хэрэгцээ, шаардлагаас хамааран өөрчлөгдөн шинэчлэгдсээр ирсэн байна. Тухайлбал, XVIII зууны үеийн 3-5 бүлэгт дууриуд XIX зууны сүүл үеэс 1 бүлэгтэй дуурь болтлоо авсаархан, цомхон болсны зэрэгцээ "Нэг хүний дуурь", XX зуунд Жазз хөгжмийн урсгал гарч ирснээр "Жазз дуурь", орчин үед "Рок дуурь" гэсэн шинэ төрөл ч бий болжээ.

?



Дуурийн цөөхүүл дууны тухай



Гоцлол дуу



Ари

Речитатив

Цөөхүүл чуулга



Хоршил

Гурвал, дөрвөл

Найрал дуу




Холимог

Нэг төрлийн

Дуурь дахь дуулаачийн төрлүүд

Дуурийг ойлгохын тулд түүнийг бүрдүүлж буй хэсгүүдийн тухай мэдэх хэрэгтэй. Дуурийн үйл явдлыг дуулаачийн гоцлол, цөөхүүл, найрал дууны төрлүүдийн оролцоотойгоор дэс дараалуулан үзүүлдэг.



Дуурь дах гоцлол төрөл

Ари-бодрол дуу. Италиар "агаар, салхи" гэсэн утгатай үг. Дуурийн гол дүрийн зан төрх, дотоод сэтгэхүй, үзэл санааг нээх зориулалт бүхий симфони найрал хөгжимтэй хамсран дуулахад зориулсан гоцлол төрөл юм. Хэлбэр бүтэц, зохиомжийн нарийн шийдэл, өргөн цараатай өгүүлэмжээрээ ялгардаг биеэ даасан хэсэг. "Ари" нь дуурийн амин сүнс болох бөгөөд дуучнаас хоолойн чадал чансаа, жүжиглэх нарийн ур дүйг шаарддагаараа онцлогтой.

Речитатив-үглэл дуу. "Уран унших" гэсэн утга бүхий латин үг. Ахуйн хэрэглээний яриан хэллэгийг аялга хэмнэлд оруулсан дуулаачийн нэг төрөл. Хөгжим болон яруу найргийг яавал сайн уялдуулж сонсогчдын сонорт хүргэж чадах вэ? хэмээн эрэлхийлсний үр дүнд яруу найргийн агуулга, хэмнэлд зохицуулан ярих мэт дуулах аргыг анх нээсэн гэдэг. Ийнхүү дуурийн үйл явдлыг өрнүүлэх гол хөшүүргийн үүрэг гүйцэтгэдэг үглэл дууны хэлбэр бий болжээ. Үглэл дууг хөгжмийн хамсраатай /найрал хөгжимтэй/ ба хамсраагүй /зөвхөн даралтат хөгжимтэй/ гэж ангилдаг.

Генри Пёрселл



Генри Пёрселл
(1659-1695)

“Дидона Эней хоёр” дуурийн Дидоны ари

Энэхүү дуурь нь Эртний Ромын яруу найрагч П.Вергилийн алдарт “Энейда” найраглалаас сэдэвлэн бүтээгджээ. 1689 онд зохиогдсон уг дуурь 200 гаруй жил мартагдсаны эцэст 1895 онд сэргээгдсэнээр дэлхийн дуурийн урын санд дахин байр сууриа эзлэх болсон билээ. Ялангуяа, Дидоны ари нь дуурийн шилдэг номеруудын нэгд зүй ёсоор тооцогддог.

Уй гашуу, уйтгар гуниг бүхий гүн гүнзгий агуулгатай уг дуурийн Дидоны арид эгшгүүдийн хагас шатлалт аялгын хөдөлгөөнийг түлхүү ашигласан нь гол дүрийн сэтгэлийн их уй гашууг дүрслэхэд тохиромжтой гэж үзсэн байна.

Дүрс бичлэгээс үзээрэй.

Adagio



Thy hand Be-lin - da, dark _____ ness shades me on thy bo- som let me

5



rest more I would - but death - in -

7



vades-me death - is now - a wel- come_ guest

- Хүний дуу хоолойг дуулах үүрэг зориулалтаар нь хэрхэн ангилдаг вэ?

Soprano - Эмэгтэй дээд хоолой




Mezzo-Soprano - Эмэгтэй тунгалаг, дээд доод хоолойн дундах хоолой



Alto - Эмэгтэй доод хоолой



Contralto - Эмэгтэй доод, бүдүүн хоолой




Дуурийн дуулаачийн хоолойн төрөл

Counter-Tenor - Эрэгтэй дээд цээл хоолой

Tenor - Эрэгтэй цээл хоолой

Bariton - Эрэгтэй доод хоолой

Bass - Эрэгтэй доод, бүдүүн хоолой



Дуурь дах цөөхүүл дуулаачийн төрөл хоршилтой танилцъя.



П.И.Чайковский

**“Гилийн хатан” дуурийн хоршил
“Хоньчин бүсгүйн чин сэтгэл”**

Оросын нэрт хөгжмийн зохиолч П.И.Чайковский “Гилийн хатан” дууриа 1890 онд Италийн Флоренц хотноо байхдаа асар богино хугацаанд зохиосон гэдэг. Оросын нэрт яруу найрагч С.Пушкины ижил нэрт туужаас сэдэвлэсэн уг дуурьт гол дүрүүд болох Лиза, Герман хоёрын аз жаргалын төлөө хүсэл тэмүүлэл нь тухайн нийгмийн бодит байдалтай зөрчилдөн итгэл найдвар алдарч байгааг сэтгэл зүйн эмгэнэлт талаас нь гүн гүнзгий товойлгон харуулсан байдаг.

Дуурийн 3-р үзэгдэлд Лиза, Герман хоёрын сэтгэхүйн драмыг орчин тойронтой нь харьцуулан, сэргүүлэн тавих зарчмыг баримтлах үүднээс хөгжмийн зохиолч үдэшлэгийн уур амьсгалыг бүрдүүлэн “Хоньчин бүсгүйн чин сэтгэл” хэмээх жүжигчилсэн үзүүлбэрийг завсрын хэсэг болгон оруулж чимж өгсөн байна.



Дуэт - Хоёр хүний бүрэлдэхүүнд зориулагдсан чуулга бүтээлийг хоршил буюу дуэт гэдэг. Өөрөөр хэлбэл хэдэн хүнд зориулагдсан гэдгээс нь шалтгаалан хоршил, гурвал, дөрвөл гэх мэтчилэн нэрлэдэг байна. Чуулгад зориулагдсан бүтээл нь дуулаачийн болон дан хөгжмийн хэмээн ангилагдана.

П.И.Чайковский “Гилийн хатан” дуурийн хоршил “Хоньчин бүсгүйн чин сэтгэл”



Дүрс бичлэгээс үзээрэй.



Дуурь дах найрал дуу

Дуурийг найрал дуугүйгээр төсөөлөхийн аргагүй. Дуулаачийн урлагт гоцлол, цөөхүүлээр дуулах төрлүүдээс гадна олон хүнийг хамарсан төрөл байдаг бөгөөд үүнийг найрал дуучид гүйцэтгэдэг.

Найрал дууны урлаг нь ард түмний бодол санаа, хүсэл эрмэлзлийг илэрхийлэх боломжоороо урлагийн бүх төрөл дотроос хамгийн их нөлөөтэй, бүх нийтийг хамарсан жинхэнэ ардач төрөл байдаг.

Найрал дуу нь Chog /Хор/ цуглаан, олуулаа гэсэн утгатай латин үгнээс гаралтай. Дуурь, оратори, кантат /магтуу/ зэрэг дуулаачийн төрлүүдэд найрал дуу зонхилох үүргийг гүйцэтгэнэ. Тухайлбал дуурьт гоцлол, цөөхүүл хэсгүүдээс гадна дуурийн гол тулгуур багана болсон найрал дуу дуурийн үйл явдалд идэвхтэй оролцогч болдог бөгөөд гол баатрын сэтгэл санааг хуваалцах, дэмжих, аливаа үйл явдлын зангилаа асуудлыг тайлахад голлох үүрэг гүйцэтгэдэг. Үүгээрээ найрал дуу нь ард түмний санаа бодлыг төлөөлдөг дуурийн чухал хэсэг юм.

К.М.Вебер



К.М.Вебер
(1786-1826)

“Шидэт харваач” дуурийн анчдын найрал дуу

Хөгжмийн зохиолч К.М.Веберын хамгийн алдартай бүтээл болох “Шидэт харваач” нь анхны романтик дуурь юм. Дуурьт немцийн ард түмний уламжлалт ёс заншил, анчдын ахуй байдлыг гэрэл-сүүдэр, сайн муугийн тэмцлийн дунд харуулна. Угалзан бүрээний яруу сайхан зөөлөн дуугаралтаар амар жимэр ойн төрх байдлыг дүрслэхийн зэрэгцээ анчдын дохио дуудлага,



бугын урамдалтыг санагдуулам дүрийг илэрхийлдэг. Анчдын найрал дууны дохио дуудлагын шинжтэй энэ аялгаас “бүрээн дуудлага маягийн” өвөрмөц өнгө дуурьслыг сонсож болно.



- Анчдын найрал дууг анхааралтай сонсоорой.


Allegretto

A musical score for the 'Anch's Song' from 'The Magic Flute'. The score is written for a single melodic line in G major and 2/4 time. It begins with a piano (p) dynamic marking and a first measure highlighted in orange. The tempo is marked 'Allegretto'. The score ends with a double bar line and a final measure highlighted in orange. A small horn icon is visible on the left side of the score.

- Ж.Вердигийн “Аида” дуурийн Ялгуусан марш, Ж.Бизегийн “Кармен” дуурийн хөвгүүдийн найрал дуу зохиолуудыг анхааралтай сонсоорой.
- Зохиол тус бүрийн шинж төрх, ижил ба ялгаатай талыг шинжиж ярилцах явцдаа хүч, хурдыг тэмдэглээрэй.



*Ж.Верди “Аида”
дуурийн Ялгуусан марш*



*Ж.Бизе “Кармен”
дуурийн хөвгүүдийн найрал дуу*